


2019 ОНЫ 04 ДУГА АР САРД ТАРАГТ СУМЫН СӨББ-ЫН

ХИЙЖ ГҮЙЦЭТГЭСЭН АЖЛЫН ТАЙЛАН

2019.04.24




№	Төлөвлөгөө	Биелэлт
1	Багш, ажилчид, эцэг эхчүүдийн дунд “Хүүхдэд ном уншиж өгөхийн ач тус” үйл ажиллагаа зохион байгуулах.	Бүлэг бүр эцэг эх хүүхдийн гурвалсан холбоог сайжруулах зорилгоор номын богц аялуулаж аав ээж хүүхдийн хамт жүжиглэсэн тоглолт үлгэр уншиж, зураг харж өгүүлбэр зохиох зэрэг олон ололттой талуудаар номын богцоо аялуулсан.
2	Гэр бүлийн тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хууль, Гэр бүлийн хүчирхийлэлийн тухай хуулийн сургалт	<p>2019 оны 4 сарын 3-10 хооронд өглөө 8³⁰-9⁰⁰ хооронд сургалтуудыг хийх хууль эрх зүйн мэдлэгээ дээшлүүлж “Хүүхэд хамгааллын хамтарсан” багаас зохион явуулж буй “АХА тэмцээнд бүх ажилчид бэлдсэн.</p> 
3	Хүүхэд хамгааллын хамтарсан баг 1 өдөр ажилсан	2019 оны 4 сарын 11 ны “Хүүхэд хамгааллын хамтарсан багийн гишүүн Баярмаа багш ажилчдын дунд Гэр бүлийн тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хууль, Гэр бүлийн хүчирхийлэлийн тухай хуулийн сургалт явуулж АХА тэмцээнийг зохион байгуулсанд туслах багш Ц. Мөнхжаргал тэргүүн байр, нярав П. Даваасүрэн Дэд байр эзэлсэн.

		
4	Малчны хотонд зочлов.	<p>Ахлах, дунд бүлгийн хүүхдүүд малчны хотонд очиж төл мал болон байр саравчтай танилцаж хөгжилтэй байгаль нийгмийн хөгжүүлэх үйл ажиллагааг мал малладаг Дэмбэрэл гэдэг айлд очиж нялх төлтэй танилцуулав.</p> 
5	Бүлгүүдийн эцэг эхийн дунд “Бид дуучин тэмцээн	<p>Цэцэрлэгийн 4 бүлгийн эцэг эхчүүдийн дунд хүүхдийн дууг хэн сайн дуулах вэ? тэмцээнийг гурван үе шаттай явуулж 1 –р шатанд хүүхдийн дууг хэн сайн дуулах вэ? тэмцээнд 34 хүн оролцсоноор хамгийн өндөр оноотой 10 хүнийг 2 – р шатанд 3 шатанд хамгийн өндөр оноотой 5 хүнийг гэх мэтээр шат дараалсан тэмцээнд Тэргүүн байранд Г. Ууганзаяа, Дэд байрт Д.Жандаг, Гутгаар байранд М. Батбаатар зэрэг уралдаанд амжилттай оролцсон.</p>

		
6	<p>Хүн байхын ухааны хэлтэрхий цуврал сургалт явуулах</p>	<p>2019 Оны 3 сарын 19 ны өдөр Эцэг эхчүүдийн харилцаа хандлагыг сайжруулах, хүүхдүүддээ хүн болох ухааныг ойлгуулж хүмүүжүүлэх зорилгоор “Хүн байхын ухааны хэлтэрхий цуврал сургалтын 5 дахь удаагийн цувралыг “Ардын уламжлалт сурган хүмүүжүүлэх ухаанаас” сэдвээр зохион явуулж, эцэг эхийн санал сэтгэгдлийг сонсон цаашдын ажлаа сайжруулахад тусган ажиллаж байна.</p> 
7	<p>Аймаг сумаас явуулж байгаа үйл ажиллагаанд сууж туршлага судлах</p>	<p>ХАЭБ сургалтанд хамрагдаж “Хөдөлмөрийн аюулгүй байдлын талаар ойлголттой болж байгууллаг дээрээ ажил хэрэг болгож ажиллаж байна.</p>

		
8	<p>Караоке</p>	<p>Багш ажилчид эцэг эхчүүдийн дунд Караоке тэмцээнд 7 баг нийт эцэг эх багш ажилчид идэвхтэй сайн оролцож Тэргүүн байранд Аялгуу баг, Дэд байранд Жавхаа баг, гутгаар байранд Тарагт баг амжилттай сайн оролцсон.</p> 

		
9.	Багш нарын ур чадварын тэмцээн	<p>Ханхөгшин бүсийн СӨБ-ын багш нарны ур чадварын тэмцээнд дүрслэх урлагийн чиглэлээр зэрлэг амьтан, гэрийн тэжээмэл амьтан, Хүнсний ногоо, ургамал, Үндсэний хувцас, Төл мал зэрэг сэдвүүдээр хөгжүүлэх үйл ажиллагааг</p> <ul style="list-style-type: none"> ➤ Уянга сумаас багш С. Мөнхцэцэг ➤ Нарийнтээл сумаас багш Д. Галсмаа ➤ Хайрхандулаан сумаас багш Б. Эрдэнэбулган ➤ Тарагт сумаас багш М.Баярмаа ➤ Жаргалант сумаас багш Н. Байгалмаа ➤ Баянтээг сумаас багш А.Чимэгмаа. <p>нар тус тус оролцож Тэргүүн байранд Жаргалант багийн багш Н. Байгалмаа бусдыгаа хошуучлан амжилттай сайн оролцлоо.</p> 

		
10	Гар бөмбөгийн тэмцээн	<p>Ханхөгшин бүсээс уламжлалт болгон зохион байгуулагддаг шилжин явах цолтой гар бөмбөгийн тэмцээн 6 сумын 6 баг тамирчин хурд хүч авхаамж самбаагаа дайчлан амжилттай сайн оролцож Баянтээг багийн баг тамирчид “Тэргүүн” байранд орж шилжин явах цолын эзэд боллоо.</p>  

ТАЙЛАН БИЧСЭН: ЗАН